



# УБЦТС ТӨХК-ИЙН САНХҮҮ

УБЦТС ТӨХК-ийн 2021 оны хагас  
жилийн санхүүгийн тайлангийн  
шинжилгээ

## НЭГ. ЗОРИЛТОТ ТҮВШНИЙ ҮЗҮҮЛЭЛТ

УБЦТС ТӨХК нь 2021 оны эхний хагас жилийн байдлаар УБ хот, Төв аймгийн хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр найдвартай хангах чиг үүргээ амжилттай хэрэгжүүлж, зорилтот түвшний үзүүлэлтийг хангаж ажиллалаа. Үүнд:

- ДҮТ ТӨХХК-иас 1,649.4 сая кВтц эрчим хүч худалдан авахаар төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 5.3 хувиар дээгүүр 1,737.6 сая кВт.ц эрчим хүч худалдан авсан. Үүнийг өмнөх оны мөн үеийн үзүүлэлттэй харьцуулбал 11.8 хувиар буюу 183.9 сая кВтц-аар илүү байна.
- Тайлант хугацаанд цахилгаан эрчим хүчний нийт алдагдал 11.78 хувь буюу 195.2 сая кВтц байхаар төлөвлөсөн, гүйцэтгэлээр 10.66 хувь буюу 185.1 сая кВтц ЦЭХ болж алдагдлын төлөвлөгөөг 1.12 пунктээр буюу 10.1 сая кВтц ЦЭХ-ээр бууруулав.
- 2021 оны эхний хагас жилд худалдан авсан цахилгааныхаа 88.22 хувь буюу 1454.65 сая кВтц ЦЭХ-ийг борлуулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 89.34 хувь буюу 1552.45 сая кВтц цахилгаан борлуулж, 98.21 сая кВтц эрчим хүчийг төлөвлөснөөс илүү борлууллаа. 2021 оны хагас жилийн борлуулсан цахилгаантай харьцуулахад 164.88 сая кВтц ЦЭХ буюу 11.88 хувиар илүү байна.
- Цахилгаан эрчим хүчний орлого төвлөрүүлэлтийн тэг үлдэгдэлтэй дансанд 226,604.17 сая төгрөгийг төвлөрүүлэхээс 216,088.21 сая төгрөгийг төвлөрүүлж, орлого төвлөрүүлэлтийн төлөвлөгөө 5.3 хувиар буюу 10,515.9 сая төгрөгөөр тасарч өмнөх оны 44,163.81 сая төгрөгийн үлдэгдэлийн хамт 54,679.78 сая төгрөгийн өглөгтэй гарлаа. Гэсэн хэдий ч 2020 оны мөн үеийн оны гүйцэтгэлээс 9.1 хувиар буюу 19,901.70 сая төгрөг илүү төвлөрүүлсэн үзүүлэлт юм.
- Тайлангийн хугацаанд үндсэн үйл ажиллагааны зардалд 35,175.50 сая төгрөгийг зарцуулахаар төсөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр 36,561.63 сая төгрөгийг зарцуулж, -1,544.1 сая төгрөгийг хэтрүүлж, үндсэн бус үйл ажиллагааны зардлыг мөн 1,464.98 сая төгрөгөөр хэмнэсэн. Энэ хэмнэлт нь үндсэн бус үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг -526.8 сая төгрөгөөр төлөвлөгөө тасарсантай холбоотой хэмнэлт болно. Борлуулалтын нэг төгрөгт ногдох зардлыг 0.98 төгрөгөөр төсөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр 0.99 мөнгө болж ашгийн төлөвлөгөөг -2,010.28 сая төгрөгөөр бууруулахад нөлөөлсөн байна.
- ЦЭХ-ийн борлуулалтын орлого 234,448.6 сая, үндсэн бус үйл ажиллагааны орлого 3,132. сая төгрөгийг олохоор төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр ЦЭХ-ийн орлогын төлөвлөгөө 4.5 хувиар буюу 10,639.53 сая төгрөгөөр давж үндсэн бус үйл ажиллагааны орлого 17 хувиар буюу -526.8 сая төгрөгөөр тасарсан байна. 2021 оны мөн үеэс ЦЭХ-ийн борлуулалтын орлого 12.6 хувиар буюу 27,536.61 сая төгрөгөөр илүү, үндсэн бус үйл ажиллагааны орлого 42.9 хувиар буюу 1,961.2 сая төгрөгөөр дутуу байна.

## Хүснэгт 1. Зорилтот түвшний үзүүлэлтүүд, сүүлийн гурван жилийн 2-р улирлаар

Д/Д	Үзүүлэлтүүд	хэмжих нэгж	2019 оны 2-р улирал гүйцэтгэл	2020 оны 2-р улирал гүйцэтгэл	2021 оны 2-р улирал		Гүйцэтгэл	
					төлөвлөгөө	гүйцэтгэл	өмнөх оноос	төлөв-с
	А	1	2	3	4	5	6=5-3	7=5-4
1	Худалдаж авах цахилгаан	сая.кВтц	1,540.8	1,553.6	1,649.4	1,737.6	184.0	88.2
2	ЦЭХ-ний алдагдал: хувиар	хувь	11.6	10.7	11.8	10.7	(0.0)	(1.1)
	биетээр	сая.кВтц	179.3	166.0	195.2	185.1	19.1	(10.1)
3	Борлуулах ЦЭХ	сая.кВтц	1,361.5	1,387.6	1,454.2	1,552.5	164.9	98.3
4	<b>Нийт орлого Үүнээс</b>	<b>сая.төг</b>	<b>226,301.1</b>	<b>256,195.9</b>	<b>268,914.6</b>	<b>279,027.3</b>	<b>22,831.4</b>	<b>10,112.7</b>
	ЦЭХ-ийн орлого	сая.төг	191,505.1	217,552.5	234,448.6	245,088.1	27,535.6	10,639.5
	Түгээх үйл ажиллагааны орлого	сая.төг	30,324.8	34,076.6	31,333.6	31,333.6	(2,743.0)	-
	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	сая.төг	4,471.2	4,566.8	3,132.4	2,605.6	(1,961.2)	(526.8)
5	<b>Нийт зардал, үүнээс:</b>	<b>сая.төг</b>	<b>219,955.6</b>	<b>254,249.4</b>	<b>264,073.0</b>	<b>276,196.0</b>	<b>21,946.6</b>	<b>12,123.0</b>
	ЦЭХ-ний төлбөр	сая.төг	183,973.3	213,248.0	225,293.5	237,337.4	24,089.4	12,043.9
	Үйл ажиллагааны зардал	сая.төг	32,789.3	37,800.0	35,017.5	36,561.6	(1,238.4)	1,544.1
	Үндсэн бус үйл ажиллагааны зардал	сая.төг	3,193.0	3,201.4	3,762.0	2,297.0	(904.4)	(1,465.0)
6	<b>Татварын өмнөх ашиг /алдагдал/</b>	<b>сая.төг</b>	<b>6,345.5</b>	<b>1,946.5</b>	<b>4,841.6</b>	<b>2,831.3</b>	<b>884.8</b>	<b>(2,010.3)</b>
	Орлогын татвар	сая.төг	739.7	303.8		478.0	174.2	478.0
	<b>Цэвэр ашиг, алдагдал</b>	<b>сая.төг</b>	<b>5,605.8</b>	<b>1,642.7</b>	<b>4,841.6</b>	<b>2,353.3</b>	<b>710.6</b>	<b>(2,488.3)</b>
7	Төрийн өмчийн ногдол ашиг	сая.төг					-	-
8	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	төгрөг	1.0	1.0	1.0	1.0	(0.0)	0.0
9	Нийт авлага:	сая.төг	<b>36,972.6</b>	<b>42,531.1</b>	<b>43,359.9</b>	<b>62,564.0</b>	<b>20,032.9</b>	<b>19,204.1</b>
	цахилгааны авлага	сая.төг	23,489.2	28,277.5	33,940.9	30,200.0	1,922.5	(3,740.9)
	бусад авлага	сая.төг	13,483.5	14,253.6	9,419.0	32,364.0	18,110.4	22,945.0
10	Нийт өр төлбөр:	сая.төг	99,756.8	91,723.1	95,766.9	120,234.3	28,511.2	24,467.4
	Богино хугацаат өр	сая.төг	45,131.7	39,289.9	63,666.9	64,895.9	25,606.0	1,229.0
	Урт хугацаат өр төлбөр	сая.төг	54,625.1	52,433.2	32,100.0	55,338.5	2,905.3	23,238.5
11	Ажиллагсадын тоо	хүн	1,919.0	1,920.0	1,920.0	1,920.0	-	-
	Цалингийн сан	сая.төг	15,734.2	17,779.9	18,173.1	17,872.1	92.2	(301.0)
	Дундаж цалин	төгрөг	1,366,528.1	1,541,602.0	1,527,035.0	1,550,189.0	8,587.0	23,154.0
12	ЦЭХ-ний борлуулалтын дундаж үнэ	төгрөг	142.6	158.7	161.2	89.4	(69.3)	(71.9)

## ХОЁР. ОРЛОГЫН ШИНЖИЛГЭЭ

Борлуулалтын орлогын өсөлт нь санхүүгийн ашигт ажиллагааг нэмэгдүүлэх үндсэн үзүүлэлт учраас дээрх орлогын эх үүсвэр ямар хүчин зүйлсийн нөлөөллөөр бий болсон болон тэдгээрийн өсч буурч байгаа хандлагад судалгаа хийлээ.

Орлогын эх үүсвэр нь:

- Цахилгаан эрчим хүчний борлуулалтын орлого
- Түгээх үйл ажиллагааны орлого
- Үндсэн бус үйл ажиллагааны орлогоос бүрдэнэ.

### Цахилгаан эрчим хүчний борлуулалтын орлого

Компани 2021 оны 2-р улирлаар 1,649.4 сая кВт.ц цахилгаан эрчим хүч худалдан авч, 88.22% буюу 1,444.6 сая кВт.ц цахилгаан эрчим хүчийг борлуулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 1,737.6 сая кВт.ц цахилгаан эрчим хүч худалдан авч 89.34% буюу 1,552.4 сая кВт.ц цахилгаан борлуулж, борлуулалт төлөвлөснөөс 98.25 сая кВт.ц-аар өссөн дүнтэй гарчээ.

#### Хүснэгт 2 Худалдан авах, борлуулах эрчим хүч

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2019 оны II улирлын гүйц	2020 оны II улирлын гүйц	2021 оны II улирлын гүйц	өсөлт/бууралт
1	Худалдан авах цахилгаан эрчим хүч	сая.кВтц	1,540.80	1,553.60	1,737.60	184.00
2	<b>ЦЭХ-ний алдагдал: хувиар</b>	<b>хувь</b>	<b>11.64</b>	<b>10.69</b>	<b>10.66</b>	-0.03
	биетээр	сая.кВтц	179.3	166.03	185.14	19.11
3	<b>Борлуулах цахилгаан</b>	<b>сая.кВтц</b>	<b>1,361.50</b>	<b>1,387.60</b>	<b>1,552.45</b>	164.85
	Үүнээс: Аж ахуйн нэгж	сая.кВтц	815.27	804.8	811.80	7.0
	Орон сууц	сая.кВтц	222.0	247.6	259.2	11.7
	Гэр хороолол	сая.кВтц	324.2	401.8	481.45	79.6

Худалдан авсан цахилгаан эрчим хүч төлөвлөснөөс 4.0%-иар буюу 88.17 сая кВт.ц-аар, цахилгаан эрчмийн алдагдлыг төлөвлөснөөс 10.07 сая кВт.ц бууруулснаар борлуулалтыг 98.2 сая кВт.ц өсгөсөн байна. Цахилгаан борлуулалтын өсөлтийг мөн тайлант хугацааны өмнөх үетэй харьцуулж харахад аж ахуй нэгж 7.0 сая кВт.ц-аар өсгөж /0.8 хувь /, Орон сууц 11.7 сая кВт.ц /4.6 хувь/ бууруулж, гэр хороолол 79.6 сая кВт.ц-аар өсгөж /19.8 хувь/ өөрөөр хэлбэл гэр хороолол оршиг ангилалын хэрэглээ хэлбэлзэл ихтэй гарсан байна. Энэ нь дулааны улиралд орон сууцны хэрэглэгчид зусланд гардагтай холбоотой гэж харж байна.

Компани 2021 оны эхний хагас жилийн өссөн дүнгээр 1,454.2 сая кВтц цахилгаан эрчим хүчийг хэрэглэгчдэд борлуулж 234,448.57 сая төгрөгийн орлого олохоор төлөвлөснөөс 1,552.4 сая кВтц цахилгаан эрчим хүчийг борлуулж, 245,088.10 сая төгрөгийн бичилтийн орлого олж орлогын төлөвлөгөөг 10,639.5 сая төгрөгөөр буюу 105.4 хувиар биелүүлсэн байна.

#### Хүснэгт 3 Борлуулалтын орлого сая.төг

№	Үзүүлэлт	хэмжих нэгж	2020 оны гүйц	2021 оны төл	2021 оны гүйц	өсөлт/бууралт
1.1	<b>Борлуулалтын орлого</b>	<b>сая.төг</b>	<b>194,156.90</b>	<b>234,448.60</b>	<b>245,088.14</b>	<b>10,639.54</b>
а	Аж ахуйн нэгж	сая.төг	129,701.00	144,303.70	144,278.90	-24.80
б	Орон сууц	сая.төг	27,763.60	36,299.90	37,792.43	1,492.53
в	Гэр хороолол	сая.төг	36,692.30	53,845.00	63,016.81	9,171.81

2021 оны 6 дугаар сарын өссөн дүнгээр хэрэглэгчдэд 1 кВт.цаг эрчим хүчийг дунджаар 161.22 төгрөгөөр борлуулахаар төлөвлөснөөс 159.20 төгрөгөөр борлуулжээ.

#### Хүснэгт 4 Борлуулалтын дундаж үнэ төг.

№	Үзүүлэлт	хэмжих нэгж	2020 оны гүйц	2021 оны төл	2021 оны гүйц	өсөлт/бууралт
1.1	<b>Борлуулалтын дундаж үнэ</b>	<b>төг/кВтц</b>	<b>142.6</b>	<b>161.22</b>	<b>159.2</b>	<b>-2.03</b>
а	ААНБ-ын хэрэглэгчдэд	төг/кВтц	159.09	179.3	178.38	-0.91
б	Орон сууцны хэрэглэгчдэд	төг/кВтц	125.06	146.63	146.31	-0.33
в	Гэр хорооллын хэрэглэгчдэд	төг/кВтц	113.17	134.01	133.78	-0.23

Нийт хэрэглээ төлөвлөснөөс 6.7%-иар буюу 98.2 сая кВт.ц-аар өссөн хэдий ч аж ахуйн нэгжийн эзлэх хувийн жингийн бууралт, гэр хорооллын хэрэглэгчид рүү 3.4%-иар шилжсэн нь цар тахлын улмаас хөл хорио тогтоож аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа хязгаарлагдсантай шууд холбоотой байна.

#### Хүснэгт 5 Худалдан авсан ЦЭХ мян кВтц

№	Үзүүлэлт	Ангилал	2021 оны эхний хагас жил		
			төлөвлөгөө	гүйцэтгэл	өсөлт/бууралт
1	Хэрэглээ /мян.кВтц/	Аж ахуйн нэгж	804,834.50	811,818.20	6,983.80
		Орон сууц	247,555.50	259,217.10	11,661.70
		Гэр хороолол	401,807.20	481,410.20	79,603.00
		<b>Нийт</b>	<b>1,454,197.10</b>	<b>1,552,445.60</b>	<b>98,248.50</b>
2	Эзлэх хувийн жин	Аж ахуйн нэгж	55.35%	52.29%	-3.05%
		Орон сууц	17.02%	16.70%	-0.33%
		Гэр хороолол	27.63%	31.01%	3.38%
		<b>Нийт</b>	<b>100.00%</b>	<b>100.00%</b>	

Тайлант хугацаанд борлуулалтын дундаж үнэ 2.03 төг/кВтц-аар унаснаар борлуулалтын орлогыг 3,147.2 сая төгрөгөөр бууруулах нөлөө үзүүлсэн бөгөөд хэрэглэгчийн ангилал тухай бүрд дундаж үнийн уналтаас 936.4 сая төгрөгийн дутагдал үүсч, харин аж ахуйн нэгж, гэр хорооллын хэрэглэгчийн хэрэглээний

хоорондох шилжилтээс хамаарсан дундаж үнийн уналтаас 2,210.8 сая төгрөгийн орлогын дутагдал үүсчээ.

2021 оны хагас жилийн гүйцэтгэлээр ДҮТ ХХК-иас 1,737.6 сая кВтц цахилгаан эрчим хүч худалдан авч цахилгаан эрчим хүчний төлбөрт 226,604.1 сая төгрөг төвлөрүүлэхээс 216,088.2 сая төгрөг төвлөрүүлж, төвлөрүүлбэл зохих орлогыг 95.36%-иар буюу 10,515.6 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлж “Нэг худалдан авагч”-ийн оны эцсийн үлдэгдэл 54,679.8 тэрбум төгрөг болоод байна.

Тайлант оны дутуу төвлөрүүлэлт нь дараахь шалтгаантай. Үүнд:

“Нэг худалдан авагч”-ийн эцсийн үлдэгдэл болох 54,679.8 сая төгрөгийн нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:

1. Монгол улсын Засгийн газрын хариуцах цхилгааны төлбөрийн үлдэгдэл 13,859.0 сая төгрөг (Монгол улсын Засгийн газрын 211-р тогтоол, Эрчим хүчний сайдын 2020 оны 269 дүгээр тушаалаар батлагдсан “Цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уурын төлбөр тооцоог зохицуулах түр журам”-ын 4.8 дугаар заалтыг баримтлан тус компанийн хэрэглэгч айл өрх, зарим аж ахуйн нэгж, байгууллагын цахилгааны төлбөрийг төрөөс хариуцах болсон)
2. Гэр хорооллын хэрэглэгчдийн шөнийн тарифын хөнгөлөлтийн дутуу санхүүжилт 14,213.3 сая төгрөг (2021 оны 1-4 сард гэр хорооллын хэрэглэгчдийн шөнийн тарифын хөнгөлөлт 124,874.0 мян.кВтц буюу 13,349.1 сая төгрөг болсон бөгөөд 5,581.2 сая төгрөгийн санхүүжилт орж, үлдэгдэл 7,767.8 сая, 2017-2020 оны дутуу санхүүжилт 6,445.5 сая төг, нийт 14,213.3 сая төгрөг)
3. Нэг худалдан авагчаас 2021 оны II улирлын дүнгээр компани руу урссан илүү санхүүжилтийн хэмжээ 14,362.1 сая төг (ЭХЗХ-ноос 2021 оны УБЦТС ТӨХК-ийн санхүүжилтийн хувийг 12.5-26.9%-иар баталснаас төлөвлөгөөт санхүүжилтээс даруй 14,362.1 сая илүү санхүүжигдсэн)
4. ЭХЗХ-ноос 12 дугаар сард цахилгаан эрчмийн алдагдлын хүлээгдэж буй гүйцэтгэлээр шахаж үнэ баталж байгаатай холбоотойгоор эрчим хүчний байгууллага хооронд эх үүсвэргүй авлагууд үүссэн нь нийлбэр дүнгээр 7,680.5 сая төгрөгт хүрсэн.

“Нэг худалдан авагч”-ийн 2021 оны II улирлын дүнгээрх өр төлбөр 54,679.8 сая төгрөгийн 91.6% буюу 50,115.9 сая төгрөг нь дээрх үндсэн 4 шалтгааны улмаас үүссэн бөгөөд компанийн үйл ажиллагаанаас хамаараагүй өр төлбөр байна.

**Хүснэгт 6. Цахилгааны борлуулалт, орлогын төлөвлөгөөний гүйцэтгэл, ХҮТ бүрээр**

ХҮТ-ийн нэр	Борлуулсан цахилгаан /сая.кВт.ц/			Борлуулалтын орлого /сая.төг/			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл /бичилтээр /	Нэхэмжлээгүй орлого	Балансын орлогын дүн
Хан-Уул	280.00	305.65	25.65	49,121.90	49,121.90	(505.55)	48,616.35
Сонгинохайрхан	293.75	311.56	17.81	48,957.30	48,957.30	(647.78)	48,309.52
Баянгол	139.46	141.17	1.71	22,561.03	22,561.03	107.41	22,668.44
Сүхбаатар	163.04	171.24	8.20	27,804.04	27,804.04	(31.78)	27,772.26
Баянзүрх	310.54	331.93	21.39	52,943.64	52,943.64	(541.53)	52,402.11
Чингэлтэй	117.75	123.35	5.60	19,610.78	19,610.78	(305.84)	19,304.94
Налайх	67.01	75.60	8.59	12,548.42	12,548.42	28.24	12,576.66
Зуунмод	38.64	44.63	5.99	6,959.64	6,959.64	(111.93)	6,847.71
Зуслан	63.36	49.26	(14.10)	6,640.16	6,640.16	(50.08)	6,590.08
<b>Компанийн дүн</b>	<b>1,473.55</b>	<b>1,554.39</b>	<b>80.84</b>	<b>247,146.91</b>	<b>247,146.91</b>	<b>(2,058.84)</b>	<b>245,088.07</b>

Хэрэглэгчдэд үйлчлэх төвүүдийн өдрийн дундаж орлого болон орлого нэхэмжлээгүй өдрийн судалгааг 7 дугаар хүснэгтээр харуулав.

Цахилгаан эрчим хүчний орлогод компанийн дүнгээр 12.21 өдрийн хэрэглээг нэхэмжлээгүй орлогоор тооцоолж орлого хүлээн зөвшөөрч бүртгэсэн нь оны эхнээс 0.35 хоногоор өссөн байна.

**Хүснэгт 7. Нэхэмжлээгүй орлого болон орлого нэхэмжлээгүй өдрийн дундаж**

	ХҮТ	Бичилтийн орлого /сая.төг/	Нэхэмжлээгүй орлого /сая.төг/	Өдөр	Өдрийн дундаж орлого	Орлого нэхэмжлээгүй өдөр	
						2021-II	2020-IV
1	Хан-Уул ХҮТ	49,121.90	(505.55)	182.00	269.90	(1.87)	(2.50)
2	Сонгино-Хайрхан ХҮТ	48,957.30	(647.78)	182.00	269.00	(2.41)	(2.33)
3	Баянгол ХҮТ	22,561.03	107.41	182.00	123.96	0.87	(1.96)
4	Сүхбаатар ХҮТ	27,804.04	(31.78)	182.00	152.77	(0.21)	(4.26)
5	Баянзүрх ХҮТ	52,943.64	(541.53)	182.00	290.90	(1.86)	(2.18)
6	Чингэлтэй ХҮТ	19,610.78	(305.84)	182.00	107.75	(2.84)	(2.55)
7	Налайх ХҮТ	12,548.42	28.24	182.00	68.95	0.41	(0.31)
8	Зуунмод ХҮТ	6,959.64	(111.93)	182.00	38.24	(2.93)	(1.87)
9	Зуслан ХҮТ	6,640.16	(50.08)	182.00	36.48	(1.37)	6.09
	<b>Дүн</b>	<b>425,425.19</b>	<b>(2,659.91)</b>		<b>1,357.95</b>	<b>(12.21)</b>	<b>(11.86)</b>

## Хүснэгт 8. Нэг хэрэглэгчийн ЦЭХ-ний хэрэглээ ба төлбөрийн шинжилгээ

Үзүүлэлтүүд	хэмжих нэгж	2018-II	2019-II	2020-II	2021-II	Хэлхээ өсөлт, %			
						2019-II	2020-II	2021-II	
Борлуулсан ЦЭХ	сая.кВт ц	1,275.55	1,361.50	1,387.57	1,552.45	107%	102%	112%	
ЦЭХ-ийн орлого	сая.төг	175,878.1	191,505.1	217,552.4	245,088.1	109%	114%	113%	
Хэрэглэгчийн нийт тоо	мян.цэг	335.08	344.10	359.51	374.55	103%	104%	104%	
Нэг хэрэглэгчийн сарын дундаж хэрэглээ ба төлбөр	Борлуулсан ЦЭХ	кВтц	634.45	659.45	643.27	690.81	104%	98%	107%
	ЦЭХ-ийн орлого	мян.төг	87.48	92.76	100.86	109.06	106%	109%	108%

Дээрхи хүснэгтийн мэдээллээс харахад борлуулсан ЦЭХ өмнөх оны мөн үеэс 12 хувийн өсөлттэй, ЦЭХ-ийн орлого 13 хувийн өсөлттэй, мөн хэрэглэгчийн тоо 4 хувь өссөн нь нэг хэрэглэгчид борлуулсан ЦЭХ-н хэмжээг 7 хувиар өсгөсөн байна.

Цахилгаан эрчим хүчний орлого нь 2020 оны хагас жилээс 12 хувь, 2019 оны хагас жилээс 27 хувь, 2018 оны хагас жилээс 39 хувь өссөн байна.

## Үндсэн бус үйл ажиллагааны орлогын гүйцэтгэл

Компани 2021 оны эхний хагас жилд 3,132.3 сая төгрөгийн үндсэн бус үйл ажиллагааны орлого олохоор төлөвлөснөөс 2,605.6 сая төгрөгийн орлоготой ажиллаж төлөвлөгөө 20 хувиар буюу 526.7 сая төгрөгөөр тасарсан. Үндсэн бус үйл ажиллагааны орлогыг бүлэглэж, нийт орлогод эзлэх хувийн жинг гаргаж сүүлийн 3 оноор зэрэгцүүлбэл, орлогын бүтцэд мэдэгдэхүйц өөрчлөлт гарсан байна. Энэ нь цар тахалтай холбоотой үйлчилгээний болон гэрээт ажлын орлогууд хумигдсантай холбоотой гэж үзэж болохоор байна.

## Хүснэгт 9. Үндсэн бус үйл ажиллагааны орлогын бүтэц, сүүлийн 3 жилээр

Үзүүлэлт	Үндсэн бус үйл ажиллагааны орлогын бүтэц					
	2019-II		2020-II		2021-II	
Алданги торгуулийн орлого	1,162.99	26.0%	706.15	15.5%	39.86	1.53%
Тоолуур баталгаажуулалтын орлого	414.77	9.3%	496.15	10.9%	351.89	13.51%
Техник үйлчилгээний орлого	931.52	20.8%	1,368.35	30.0%	967.31	37.12%
Зураг төсвийн орлого	11.72	0.3%	29.95	0.7%	10.08	0.39%
Реле хамгаалалт туршилт тохируулгын орлого	124.59	2.8%	56.33	1.2%	49.91	1.92%
Төсвөөр гүйцэтгэсэн гэрээт ажлын орлого	354.82	7.9%	466.00	10.2%	208.39	8.00%
УБЦТС ТӨХК-д ногдох хог, телевизийн хураамжийн орлого	858.25	19.2%	736.30	16.1%	326.04	12.51%
Бусад орлого	612.56	13.7%	707.48	15.5%	652.11	25.03%
<b>НИЙТ ДҮН</b>	<b>4,471.22</b>	<b>100.0%</b>	<b>4,566.71</b>	<b>100%</b>	<b>2,605.60</b>	<b>100%</b>



Дээрх хүснэгтээс харахад орлогын төрөл бүр 2021 оны эхний хагас жилийн байдлаар илт буурсан байна. Ялангуяа үндсэн бус орлогын ихэнхи хувийг бүрдүүлдэг техник үйлчилгээний орлого, төсөвт ажлын орлого, хог, телевизийн хураамжийн орлого буурсан байна.

Хог, телевизийн хураамж нь УБЦТС ТӨХК нь өөрийн сүлжээгээр дамжуулан бусдын өмнөөс шинэ хэрэглэгчийг бүртгэх, мөн тэдний орлогыг цуглуулж өгсөний төлөө авч буй үйлчилгээний шимтгэл болно. Тоолуур баталгаажуулалт, техникийн үйлчилгээ, релей хамгаалалт, туршилт тохируулгын орлого нь тусгай зөвшөөрлийн хүрээнд хэрэглэгчдэд захиалга болон хүсэлтийн үндсэнд үзүүлэх үйлчилгээний орлого байна. Харин бусад орлого өөрчлөлт байгатай байгаа нь хойшлогдсон орлогыг хүлээн зөвшөөрч бүртгэсэнтэй холбоотой байна.

Бусад орлогод дээр бүлэглэж харуулсан тодорхой үйл ажиллагааны чиглэлд хамаарагдахгүй дараах орлогуудыг нэгтгэв. Үүнд:

- Хөрөнгө борлуулсны орлого
- Дэвтэр, баримтын болон мессеж үйлчилгээний орлого
- Сургалтын орлого
- Үнэ төлбөргүй хөрөнгийн орлого /Хойшлогдсон орлогоос/
- Тендерийн материалын орлого гэх мэт болно.

## Цахилгааны борлуулалтын мөнгөн урсгалын шинжилгээ

Цахилгаан эрчим хүчний төлбөрийн мөнгөний урсгал ЭХЗХ-оос баталсан Нэг худалдан авагчтай загварын дагуу зохицуулагддаг. Хэрэглэгчдийн цахилгааны төлбөр компанитай гэрээтэй арилжааны 5 банкаар /ХААН, Голомт, Төрийн банк, Худалдаа хөгжил, Хас/ дамжин ДҮТ ТӨХХК-ийн Тэг үлдэгдэлтэй орлогын нэгдсэн дансанд төвлөрдөг.

### Хүснэгт 10. Цахилгааны орлого төвлөрүүлэлт, санхүүжилтийн хуваарилалт

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2019-II	2020-II	2021-II	Өсөлт, бууралт		
					2019-II	2020-II	2021-II
ХАЦ	сая.кВтц	1,540.89	1,553.61	1,737.59	105.8%	100.8%	111.8%
Дотоод тооцооны үнэ	төг/кВтц	120.09833	137.26	136.59	102.9%	114.3%	99.5%
Төвлөрүүлбэл зохих орлого	сая төг	169,013.45	201,988.42	226,604.18	110.0%	119.5%	112.2%
ТҮОД, үүнээс:	сая төг	193,284.62	227,663.52	256,065.28	105.7%	117.8%	112.5%
Зардал	сая төг	34,138.06	41,352.25	50,667.48	91.8%	121.1%	122.5%
ДҮТ	сая төг	1,804.79	2,100.44	1,991.16	155.3%	116.4%	94.8%
ТҮОНД /харилцахаар/	сая төг	167,998.74	196,186.51	216,088.21	108.6%	116.8%	110.1%

2021 оны эхний хагас жилээр тэг үлдэгдэлтэй орлогын дансанд 256,065.2 сая төгрөг банкаар, хоорондоор 12,681.5 сая төгрөг нийт 268,746.8 сая төгрөг төвлөрүүлсэнээс ЭХЗХ-оос баталсан зардал хуваарилах коэффициентийн дагуу манай компанид буцаан 50,667.5 сая төгрөгийн зардал санхүүжүүлэх эх үүсвэр хуваарилагдсан түүнчлэн ДҮТ ТӨХХК нь 1,991.1 сая төгрөгийн санхүүжилтийг шууд татан авснаар ТҮОНДансад 216,088.2 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлжээ.

### Хүснэгт 11. Цахилгааны орлого төвлөрүүлэлтийн үзүүлэлт

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2019-II	2020-II	2021-II
Төвлөрүүлбэл зохих	сая төгрөг	169,013.45	201,988.42	226,604.18
Төвлөрүүлсэн	сая төгрөг	167,998.74	196,186.51	216,088.21
Төвлөрүүлэлтийн хувь	хувь	99.4%	97.1%	95.4%
Илүү/дутуу төвлөрүүлэлт	сая төгрөг	-1,014.71	-5,801.91	-10,515.96

2018 оноос өмнө хагас жилийн байдлаар тухайн он дотроо төвлөрүүлэлт давуулан биелүүлдэг байсан бол 2019 оноос хойш 95.4-99.4 хувьтай төвлөрдөг болсон байна.

Нэг худалдан авагчийн дансанд төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө 2021 оны эхний 2021 оны хагас жилийн гүйцэтгэлээр ДҮТ ХХК-иас 1,737.6 сая кВтц цахилгаан эрчим хүч худалдан авч цахилгаан эрчим хүчний төлбөрт 226,604.1 сая төгрөг төвлөрүүлэхээс 216,088.2 сая төгрөг төвлөрүүлж, төвлөрүүлбэл зохих орлогыг 95.36%-иар буюу 10,515.6 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлж “Нэг худалдан авагч”-ийн оны эцсийн үлдэгдэл 54,679.8 тэрбум төгрөг болоод байна.



Тайлант оны дутуу төвлөрүүлэлт нь дараахь шалтгаантай. Үүнд:

“Нэг худалдан авагч”-ийн эцсийн үлдэгдэл болох 54,679.8 сая төгрөгийн нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:

- Монгол улсын Засгийн газрын хариуцах цхилгааны төлбөрийн үлдэгдэл 13,859.0 сая төгрөг (Монгол улсын Засгийн газрын 211-р тогтоол, Эрчим хүчний сайдын 2020 оны 269 дүгээр тушаалаар батлагдсан “Цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уурын төлбөр тооцоог зохицуулах түр журам”-ын 4.8 дугаар заалтыг баримтлан тус компанийн хэрэглэгч айл өрх, зарим аж ахуйн нэгж, байгууллагын цахилгааны төлбөрийг төрөөс хариуцах болсон)
- Гэр хорооллын хэрэглэгчдийн шөнийн тарифын хөнгөлөлтийн дутуу санхүүжилт 14,213.3 сая төгрөг (2021 оны 1-4 сард гэр хорооллын хэрэглэгчдийн шөнийн тарифын хөнгөлөлт 124,874.0 мян.кВтц буюу 13,349.1 сая төгрөг болсон бөгөөд 5,581.2 сая төгрөгийн санхүүжилт орж, үлдэгдэл 7,767.8 сая, 2017-2020 оны дутуу санхүүжилт 6,445.5 сая төг, нийт 14,213.3 сая төгрөг)
- Нэг худалдан авагчаас 2021 оны II улирлын дүнгээр компани руу урссан илүү санхүүжилтийн хэмжээ 14,362.1 сая төг (ЭХЗХ-ноос 2021 оны УБЦТС ТӨХК-ийн санхүүжилтийн хувийг 12.5-26.9%-иар баталснаас төлөвлөгөөт санхүүжилтээс даруй 14,362.1 сая илүү санхүүжигдсэн)
- ЭХЗХ-ноос 12 дугаар сард цахилгаан эрчмийн алдагдлын хүлээгдэж буй гүйцэтгэлээр шахаж үнэ баталж байгаатай холбоотойгоор эрчим хүчний байгууллага хооронд эх үүсвэргүй авлагууд үүссэн нь нийлбэр дүнгээр 7,680.5 сая төгрөгт хүрсэн.

Тайлант хугацааны дансны өглөг 54,679.8 сая төгрөгийн 91.6% буюу 50,115.9 сая төгрөг нь дээрх үндсэн 4 шалтгааны улмаас үүссэн бөгөөд компанийн үйл ажиллагаанаас хамаараагүй өр төлбөр гэж үзэж болохоор байна.

Зураг 1. ЦЭХ-ийн авлагын өсөлт, хэрэглэгчийн сегментээр



Эндээс харахад ААН-н авлага нь нийт авлагын 46-59 хувийг тогтмол эзлэж байна.

Хүснэгт 12. ЦЭХ-ний авлагын ангилал сая.төг

Авлагын ангилал	2020-IV		2019-II		2020-II		2021-II	
	Төг	Хувь	Төг	Хувь	Төг	Хувь	Төг	Хувь
Гэр хороолол	3,069.04	12%	4,238.51	32%	8,094.12	40%	6,370.0	32%
Орон сууц	9,664.17	38%	2,890.15	22%	2,817.12	14%	1,793.4	9%
Аж ахуй нэгж	13,022.25	51%	6,172.72	46%	9,124.59	46%	11,681.2	59%
<b>Дүн</b>	<b>25,755.46</b>	<b>100%</b>	<b>13,301.38</b>	<b>100%</b>	<b>20,035.83</b>	<b>100%</b>	<b>19,844.57</b>	<b>100%</b>

ЭХЗХ-ноос улирал бүр баталдаг мөнгөний урсгалын хувь хэмжээг баримтлан ДҮТ ТӨХХК-ийн тэг үлдэгдэлтэй орлогын нэгдсэн дансанд төвлөрүүлсэн орлогоос УБЦТС ТӨХК-ний үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг хуваарилдаг.

**Хүснэгт 13. Батлагдсан санхүүжилт, гүйцэтгэл**

Сар	Санхүүжилт ийн хувь	Санхүүжилт т тооцсон	Авсан санхүүжилт	Санхүүжилтийн гүйцэтгэл	
				биет	хувь
1 сар	12.55	6,862.73	3,855.75	3,006.98	0.56
2 сар	15.94	6,862.73	10,085.76	(3,223.03)	1.47
3 сар	15.94	6,428.12	5,728.84	699.28	0.89
4 сар	15.94	6,185.71	4,452.53	1,733.18	0.72
5 сар	26.86	5,851.39	11,655.68	(5,804.29)	1.99
6 сар	26.86	6,356.85	14,888.93	(8,532.07)	2.34
<b>Хагас жилийн дүн</b>		<b>38,547.53</b>	<b>50,667.48</b>	<b>(12,119.95)</b>	1.31

Тэг үлдэгдэлтэй орлогын дансанд төвлөрүүлэх орлогоос санхүүжилтэд хуваарилах хувийг харгалзан тооцоолбол компани 38.547.3 сая төгрөгийн санхүүжилт авах ёстой боловч Засгийн газрын 211 дүгээр тогтоолын хүрээнд хөнгөлөлтийн орлого сарын эцэст төвлөрч буцах санхүүжилтийн хувийг өөрчлөөгүйгээс санхүүжилтийн хувь хэмжээ хэтэрсэн байна. Энэ нь ТҮОНДансанд төвлөрч амжилгүй дансны өглөгийг нэмэгдүүлдэг байна.

**ГУРАВ. ЗАРДЛЫН ШИНЖИЛГЭЭ**

Аливаа байгууллага үйл ажиллагааны зардлын төлөвлөлтийг нарийвчлан боловсруулах, зарцуулалтын механизмуудыг боловсронгуй болгох нь бизнесийн тогтвортой байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой байдаг.

2021 оны эхний хагаст нийт 264,072.9 сая төгрөг, үүнээс 225,293.5 сая төгрөгийг цахилгаан эрчим хүчний төлбөрт 35,017.5 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны зардалд 3,761.9 сая төгрөгийг үндсэн бус үйл ажиллагааны зардалд зарцуулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 4.5 хувиар буюу -12,123.0 сая төгрөгөөр хэтэрч 276,195.9 сая төгрөг зарцуулсан байна. Үүнээс 237,337.4 сая төгрөгийг цахилгаан эрчим хүчний төлбөрт, 36,561.6 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны зардалд 2,296.9 сая төгрөгийг үндсэн бус үйл ажиллагааны зардалд тус тус зарцууллаа.

**Үйл ажиллагааны зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл**

Зардлын гүйцэтгэлийг ЭХЗХ-оос баталсан зардлын ангиллаар сүүлийн 3 жилээр харьцуулж үзэхэд дараах байдалтай байна.

Зардлын сегмент бүрээр үзвэл тогтмол өсөлттэй зардлууд байна. Энэ өсөлт нь цалин хөлс, элэгдлийн зардал, ДҮТ-ийн зардалд ажиглагдаж байна. Нийт зардлын өсөлтийг ЦЭХ-ийн борлуулалтын орлогын өсөлттэй зэрэгцүүлэхэд зохистой хэмжээнд байна. Өөрөөр хэлбэл өмнөх оны мөн үеэс 2 хувийн бууралттай, харин 2019 оны мөн үеэс 11 хувийн өсөлттэй байна. Цахилгаан эрчим хүчний орлого нь 2020 оны хагас жилээс 13 хувь, 2019 оноос 28 хувь, 2018 оноос 39 хувь өссөн байна.

**Хүснэгт 14. Зардлын гүйцэтгэл, 2019-2021 оны хагас жил сая.төг**

№	Зардлын ангилал	2019.06 өссөн дүн	2020.06 өссөн дүн	2021.06 өссөн дүн		Өөрчлөлт			
				Төлөв	Гүйц	2020.06-аас		Төлөв-с	
						биет	хувь	биет	хувь
1	Шатахууны зардал	339.7	360.9	354.9	290.2	-70.7	-20%	-64.7	-18%
2	Тээврийн зардал	108.6	115.2	89.9	100.9	-14.3	-12%	11	12%
3	Сэлбэг хэрэгсэл	156.1	202.9	275.3	118.7	-84.2	-42%	-156.6	-57%
4	Урсгал засвар	1,090.00	1,297.90	1,447.30	833.7	-464.3	-36%	-613.7	-42%
5	Үндсэн ба нэмэгдэл цалин, хөлс	15,734.20	17,655.80	17,458.60	17,751.90	96.2	1%	293.3	2%
6	Байгууллагаас төлөх ЭМ, НДШ	2,446.00	2,706.00	2,531.50	2,900.40	194.4	7%	368.9	15%
7	Ашиглалтын зардал-Цахилгаан	323.8	388.3	388.7	375.1	-13.2	-3%	-13.6	-3%
8	Ашиглалт зардал-Дулаан	78.3	86.3	81.1	84.6	-1.7	-2%	3.5	4%
9	Ашиглалт зардал-Ус	23.3	26.2	24.6	14.5	-11.6	-44%	-10	-41%
10	Албан томилолтын зардал	105	41.4	48.6	16.7	-24.7	-60%	-31.9	-66%
11	Конторын хангамжийн зардал	149.7	212.9	177.2	108.2	-104.7	-49%	-68.9	-39%
12	Харилцаа холбооны зардал	87.5	99	137.9	146.2	47.2	48%	8.3	6%
13	Харуул хамгаалалтын зардал	260	287.1	292.2	296.2	9.1	3%	4	1%
14	Хөдөлмөр хамгааллын зардал	196.2	423.7	654.1	214.8	-208.9	-49%	-439.3	-67%
15	Даатгалын зардал	53.9	55	52.9	-	-55	-100%	-52.9	-100%
16	Гүйцэтгэх удирдлагын зардал	20.6	162.9	173.6	144.2	-18.7	-11%	-29.4	-17%
17	ТУЗ-ын зардал	28.2	42.1	63.6	61.6	19.5	46%	-2.1	-3%
18	Маркетинг зар суртны зардал	30.7	25.4	49.8	32	6.6	26%	-17.8	-36%
19	Диспетчерийн үйлчний зардал	1,437.80	1,663.70	1,556.90	1,754.00	90.2	5%	197.1	13%
20	Зохицуулалтын үйлчний хөлс	85.8	126.7	118.6	121.6	-5.1	-4%	3	3%
21	Гадны үйлчилгээний хөлс	420.2	617.8	958.1	286.9	-330.9	-54%	-671.2	-70%
22	Түрээсийн зардал	175.3	113.7	98.5	165	51.3	45%	66.6	68%
23	Сургалтын зардал	32.3	13.1	74.8	6.8	-6.3	-48%	-68	-91%
24	Үйл ажиллагааны бусад зардал	0.2	0.5	-	0	-0.4	-94%	0	
<b>Үйл ажиллагааны зардлын дүн</b>		<b>23,383.30</b>	<b>26,724.50</b>	<b>27,108.60</b>	<b>25,824.20</b>	<b>-900.4</b>	<b>-3%</b>	<b>1,284.50</b>	<b>-5%</b>
25	Элэгдлийн зардал	7,816.80	8,426.00	6,092.60	9,096.00	670	8%	3,003.40	49%
26	Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	49.6	26.9	60.9	70.9	44.1	164%	10	16%
27	АТӨЯХ-ийн албан татвар	15.6	13.3	19.4	5.2	-8	-61%	-14.2	-73%
28	Газрын төлбөр	5.4	0.3	30	0.2	-0.1	-26%	-29.8	-99%
31	Бусад татвар хураамж	-	-	-	-	-		-	
<b>ОАТ-аас бусад албан татвар</b>		<b>70.6</b>	<b>40.4</b>	<b>110.3</b>	<b>76.4</b>	<b>36</b>	<b>89%</b>	<b>-34</b>	<b>-31%</b>
<b>БҮРЭН ӨӨРИЙН ӨРТӨГ</b>		<b>31,270.60</b>	<b>35,190.90</b>	<b>33,311.50</b>	<b>34,996.50</b>	<b>-194.4</b>	<b>-1%</b>	<b>1,685.00</b>	<b>5%</b>
29	Урт хугацаат зээлийн хүү	327.5	309.4	293.8	292.9	-16.5	-5%	-0.8	0%
30	Ажиллагсдын нийгмийн зардал	1,191.20	1,762.60	1,412.20	1,193.40	-569.2	-32%	-218.8	-15%
<b>Хөрөнгө оруулалтын өгөөж</b>		<b>1,518.70</b>	<b>2,072.10</b>	<b>1,706.00</b>	<b>1,486.30</b>	<b>-585.8</b>	<b>-28%</b>	<b>-219.6</b>	<b>-13%</b>
<b>НИЙТ ЗАРДАЛ</b>		<b>32,789.30</b>	<b>37,263.00</b>	<b>35,017.50</b>	<b>36,561.64</b>	<b>-780.2</b>	<b>2.10%</b>	<b>1,544.14</b>	<b>4.20%</b>

Зардлын бүтцийг хувьсах ба тогтмол шинжээр нь бүлэглэвэл, нийт зардлын 60 хувь нь тогтмол зардал байна. Зардлыг бүтцийг ангиллаар авч үзвэл дараах дүр зурагтай байна.

#### Хүснэгт 15. Зардлын бүтэц

Зардлын зүйл	2019-II	2020-II	2021-II
Засвар, үйлчилгээний зардал	3.8%	4.0%	2.6%
Цалин хөлс, НДШ-ийн зардал	55.4%	54.6%	56.5%
Ашиглалтын зардал	1.3%	1.3%	1.3%
Үйл ажиллагааны зардал	4.6%	4.9%	4.1%
Элэгдлийн зардал	23.8%	22.6%	24.9%
Үйлчилгээний хөлс, төлбөр	7.2%	7.6%	7.1%
Хүү, татвар, хураамж	0.2%	0.1%	0.2%
Ажиллагсдын нийгмийн арга хэмжээний зардал	3.6%	4.7%	3.3%
<b>Бүгд дүн</b>	<b>100%</b>	<b>100%</b>	<b>100%</b>

Компанийн үйл ажиллагааны онцлогоос хамааран нийт зардлын дүнд цалингийн зардал 50-аас дээш, элэгдлийн зардал 20-оос дээш хувь байна. Ер нь сэлбэг хэрэгсэл, урсгал засвар, цалин хөлс, элэгдлийн зардал нь хэдийгээр тогтмол зардал мөн боловч үйл ажиллагааны болон шугам тоноглолын өсөлтийг тодорхой хэмжээнд дагаж өсдөг хагас хувьсах хэлбэрийн зардал болно. Иймээс, дээр зардлуудыг мөнгөн дүнгээр өсөлт, бууралтыг авч үзэхээс илүү нийт зардлын дүнд эзлэх хувийн жингийн өөрчлөлтийг хянаж байх нь оновчтой болно.

#### Хүснэгт 16. Үйл ажиллагааны чиглэлээр бүлэглэсэн зардлын бүтэц

ҮА-ны чиглэл	2018-II	2019-II	2020-II	2021-II	зардал д эзлэх хувь	2021/2020	2021/2019	2021/2018
Түгээх	15,985.6	17,326.4	19,418.7	19,925.4	54%	103%	115%	125%
Хангах	11,634.5	11,525.0	12,583.2	12,003.5	33%	95%	104%	103%
Нийтлэг	3,898.3	3,937.9	5,798.1	4,632.8	13%	80%	118%	119%
<b>Үндсэн ү/а-ны зардал</b>	<b>31,518.4</b>	<b>32,789.3</b>	<b>37,800.1</b>	<b>36,561.6</b>	<b>100%</b>	<b>97%</b>	<b>112%</b>	<b>116%</b>
Үндсэн бус ү/а-ны зардал	2,440.5	3,192.9	3,201.4	2,297.0	7%	72%	72%	94%
<b>Нийт зардал</b>	<b>29,077.9</b>	<b>29,596.3</b>	<b>34,598.7</b>	<b>34,264.6</b>				

Үйл ажиллагааны чиглэлээр бүлэглэсэн зардлын бүтцээс харахад нийтлэг болон удирдлагын зардал нь өмнөх оны түвшинд байж, нийт зардалд эзлэх хувийн жин буурч байна. Хангах үйл ажиллагааны зардал нь хэрэглэгчийн цэгийн өсөлт, түүнийг дагаж бий болох газар нутгийн тэлэлтийг дагаж өсдөг бол түгээх үйл ажиллагааны зардал нь цахилгаан дамжуулах шугам тоноглолын өсөлтийг дагаж бий болно. Гэхдээ түгээх үйл ажиллагааны өсөлтийг дагаж хангах үйл ажиллагааны өсөлт явагддаг тул дээрх хүснэгтэнд харуулсан хувь харьцааг бүхэлд нь авч үзвэл зохистой хэмжээнд байна.

#### Хүснэгт 17. Зардлын хэтрэлт, хэмнэлт

№	Зардлын ангилал	2019.06 өссөн дүн	2020.06 өссөн дүн	2021.06 өссөн дүн		Өөрчлөлт			
				Төлөв	Гүйц	2020.06-аас		Төлөв-с	
						биет	хувь	биет	хувь
1	Тээврийн зардал	108.6	115.2	89.9	100.9	-14.3	-12%	11	12%
2	Үндсэн ба нэмэгдэл цалин, хөлс	15,734.20	17,655.80	17,458.60	17,751.90	96.2	1%	293.3	2%
3	Байгууллагаас төлөх ЭМ, НДШ	2,446.00	2,706.00	2,531.50	2,900.40	194.4	7%	368.9	15%
4	Ашиглалт зардал-Дулаан	78.3	86.3	81.1	84.6	-1.7	-2%	3.5	4%
5	Харилцаа холбооны зардал	87.5	99	137.9	146.2	47.2	48%	8.3	6%
6	Харуул хамгаалалтын зардал	260	287.1	292.2	296.2	9.1	3%	4	1%
7	Зохицуулалтын үйлчллийн хөлс	85.8	126.7	118.6	121.6	-5.1	-4%	3	3%
8	Түрээсийн зардал	175.3	113.7	98.5	165	51.3	45%	66.6	68%
9	Элэгдлийн зардал	7,816.80	8,426.00	6,092.60	9,096.00	670	8%	3,003.40	49%
10	Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	49.6	26.9	60.9	70.9	44.1	164%	10	16%
<b>ДҮН</b>		<b>26,842.00</b>	<b>29,642.70</b>	<b>26,961.70</b>	<b>30,733.70</b>	<b>1,091</b>	<b>3.70%</b>	<b>3,772.0</b>	<b>14.0%</b>

2021 оны хагас жилийн зардлын бүтцэд бага зэрэг өөрчлөлт ажиглагдаж байна. Энэ нь Коронавируст /Ковид 19/ цар тахлын улмаас хол хорио тогтоосон, бизнесийн үйл ажиллагаанууд зогссонги байдалд орсонтой холбоотойгоор компанийн үйл ажиллагааны хэмнэл удааширсан, ажлын цагийг ээлжинд оруулж зохион байгуулсан болон, осол аваарь саатлаас урьдчилан сэргийлэх зорилгоор өдөр тутмын үйл ажиллагаанд өөрчлөлт орсонтой мөн холбоотой. Дээрх хүснэгтэнд батлагдсан төлөвлөгөөнөөс +5 хувийн өөрчлөлттэй зардал тус бүрийг оруулж, 2019-2020 оны эхний хагас жилийн гүйцэтгэлтэй харьцуулж бэлтгэсэн. Ингээд хэтэрч хэмнэсэн зардал тус бүрээр санхүүгийн тайланд үндэслэн хэтэрч хэмнэсэн шалтгааныг товч дурдвал:

- Үндсэн хөрөнгийн элдэгдэлийн зардал: Төлөвлөсөн хэмжээнээс 3,003.4 сая төгрөгөөр буюу 49.0 хувиар хэтэрсэн. 2021 оны тарифын саналд элэгдлийн зардлыг 16,479.3 сая төгрөг байхаар тооцож ЭХЗХ-нд санал хүргүүлсэн боловч ЭХЗХ-оос БОШХ-д элэгдлийн зардлыг 2021 оны жилийн түвшинд 12,286.1 сая төгрөг байхаар тусгасан нь нөлөөлсөн.
- Үндсэн ба нэмэгдэл цалин, хөлс: Төлөвлөсөн хэмжээнээс 293.3 сая төгрөгөөр буюу 2 хувиар хэтэрсэн үзүүлэлттэй гарсан байна.
- Байгууллагаас төлөх ЭМ, НДШ: Төлөвлөсөн хэмжээнээс 368.9 сая төгрөгөөр буюу 15 хувиар хэтэрсэн. Цалингийн зардлын хэтрэлт нөлөөлсөн байна.
- Тээврийн зардал: Төлөвлөсөн хэмжээнээс 11.0 сая төгрөгөөр буюу 12 хувиар хэтэрсэн. Цахилгааны хөнгөлөлтөөс үүдэн шуурхай үйлчилгээний автомашинуудаар зайлшгүй үзлэг хийх болсонтой холбоотой нөлөөлсөн байгаа.
- Дулааны зардал: Төлөвлөсөн хэмжээнээс 3.5 сая төгрөгөөр буюу 4 хувиар хэтэрсэн.
- Харилцаа холбооны зардал: Төлөвлөсөн хэмжээнээс 8.3 сая төгрөгөөр буюу 6 хувиар хэтэрсэн.
- Харуул хамгаалалтын зардал: Төлөвлөсөн хэмжээнээс 4.0 сая төгрөгөөр буюу 1 хувиар хэтэрсэн.

- Түрээсийн зардал: Төлөвлөсөн хэмжээнээс 66.6 сая төгрөгөөр буюу 68 хувиар хэтэрсэн. Зуунмод ТТ 9.7 сая төгрөгөөр хэтэрч байгаа, энэ нь Зуунмод ТТ шинэ байранд орсонтой холбоотой.
- Үл хөдлөх хөрөнгийн албан татварын зардал: Төлөвлөсөн хэмжээнээс 10.0 сая төгрөгөөр хэтэрсэн.

## Үндсэн бус үйл ажиллагааны зардлын гүйцэтгэл

Компани 2021 оны эхний хагаст 3,761.9 сая.төгрөгийн үндсэн бус үйл ажиллагааны зардал зарцуулахаар төлөвлөснөөс 2,296.9 сая төгрөгийн зардал гаргаж -1,464.9 сая төгрөгөөр хэмнэсэн. Энэ хэмнэлт нь Үндсэн бус үйл ажиллагааны орлогын бууралттай холбоотой бөгөөд үүнийг нэгж орлогод ногдуулан тооцвол төсөвлөснөөр 1.2 төгрөг байгаа бөгөөд гүйцэтгэлээр 0.88 төгрөг болж, үндсэн бус үйл ажиллагааны орлогын нэг төгрөг тутам гарах зардлыг 31.8 мөнгөөр хэмнэсэн.

## ДӨРӨВ. АШГИЙН ШИНЖИЛГЭЭ

### Ашгийн үзүүлэлт

Шинжилгээний өмнөх хэсгүүдэд дурдагдсан ажил үйлчилгээний үр дүн бүр үйл ажиллагааны үндсэн шалгуур үзүүлэлт болох ашиг/алдагдал/-д хэрхэн нөлөөлснийг дараах хүснэгтээр харууллаа.

#### Хүснэгт 18. Энергийн болон санхүүгийн баланс

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>Энергийн баланс</b>			
Худалдан авсан цахилгаан	мян.кВтц	1,649.41	1,737.58
Алдагдал, хувиар	%	11.84	10.66
Алдагдал, биет хэмжээгээр	мян.кВтц	195.29	185.23
Бичсэн цахилгаан	мян.кВтц	1,454.12	1,552.35
<b>Санхүүгийн баланс</b>			
Ашиг, алдагдал	сая. төг	4,841.70	2,831.29
Нийт орлого	сая. төг	<b>268,914.55</b>	<b>279,027.26</b>
Борлуулалтын орлого	сая. төг	234,448.60	245,088.11
Түгээх үйлчилгээний орлого	сая. төг	31,333.55	31,333.55
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	сая. төг	3,132.40	2,605.60
<b>Нийт өртөг, зардал</b>			
Нийт өртөг зардал	сая. төг	<b>264,072.85</b>	<b>276,195.97</b>
Худалдан авсан цахилгааны өртөг	сая. төг	225,293.40	237,337.35
Үйл ажиллагааны зардал	сая. төг	35,017.48	36,561.63
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	сая. төг	3,761.97	2,296.99

Компани 2021 оны хагас жилээр 4,841.5 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажиллахаар төлөвлөсөн бол гүйцэтгэлээр 2,831.2 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.



## Ашигт нөлөөлсөн хүчин зүйлсийн шинжилгээ

Ашигт ажиллагаанд эерэгээр нөлөөлөх үндсэн хүчин зүйл нь орлогын өсөлт ба зардлын хэмнэлт бөгөөд эдгээр хүчин зүйлс манай алдагдалд хэрхэн нөлөөлснийг дараах шинжилгээгээр харуулав.

### Хүснэгт 19. Ашгийн хүчин зүйлсийн нөлөөллийн шинжилгээ

	хэмжих нэгж	2021 оны 2-р улирал	
Ашиг алдагдал /ТТӨ/	сая.төг		2,831.3
Төлөвлөгөөт ашиг/алдагдал	сая.төг		4,841.6
Төлөвлөгөөнөөс хазайлт	сая.төг		<b>(2,010.2)</b>
Хэрэглээний өөрчлөлтийн нөлөө	сая.төг		<b>(12,043.8)</b>
Хэрэглээний өөрчлөлт	сая.кВтц	88.17	
Техникийн болон борлуулалтын алдагдлын нөлөө	сая.төг		<b>1,590.3</b>
Алдагдлын өөрчлөлт	сая.кВтц	10.07	
Борлуулалтын дундаж үнийн нөлөө	сая.төг		<b>8,522.5</b>
Борлуулалтын дундаж үнийн өөрчлөлт	төг/кВтц	4.59	
Борлуулалтын хөнгөлөлт	сая.төг		
Зардлын хэтрэлтээс /Үндсэн болон үндсэн бус/	сая.төг		<b>(79.2)</b>

Дээрх хүснэгтээс харахад 2021 оны хагас жилийн санхүүгийн тайлан балансаар татвар тооцохын өмнө 2,831.28 сая төгрөгийн ашигтай ажиллахад хүчин зүйлс нөлөөлсөн байна.

Үүнд:

- ХАЦЭХ, дотоод тооцооны үнэ,
  - Борлуулсан ЦЭХ, дундаж үнэ,
  - ЦЭХ-ний алдагдлын бууралт,
  - Үйл ажиллагааны зардлын өсөлт тус тус нөлөөлсөн байх магадлалтай байна.
- Цахилгаан эрчим хүчний төлөвлөгөөт алдагдлыг 10.07 сая.кВтц бууруулснаар 1,590.3 сая төгрөгийн ашиг нэмэгдсэн;
- Борлуулсан цахилгаан 98.17 сая.кВтц-аар өссөнөөр төлөвлөгөөт ЦЭХ –ийн орлого 9,049.2 сая төгрөгөөр өсч, үндсэн бус орлого төлөвлөгөөнөөс 526.77 сая төгрөгөөр тасарсан /зөрүү нь 8,522.5/ хэдий ч нийт орлого 10,112.76 сая төгрөгөөр давсан байна.
- Худалдан авсан цахилгаан 88.17 сая.кВтц-аар өсч ЦЭХ-ний өртөг 12,403.87 сая төгрөгөөр хэтэрч, Үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны зардлын хэтрэлтээс -79.2 сая төгрөгийн алдагдал, нийт 12,123.04 сая төгрөгийн хэтрэлт гарсан байна.

### Хүснэгт -20. ХАЦЭХ ба дотоод тооцооны үнийн өсөлтийн нөлөөллийн шинжилгээ

	Үзүүлэлт	2019-II	2020-II	2021-II
1	ХАЦЭХ, мян.кВтц	1,540,886.70	1,553,605.60	1,737,589.50
2	Дотоод тооцооны үнэ, төгрөг	120.09	137.26	136.59
3	ХАЦЭХ-ний төлбөр, мян төгрөг	183,973,346.18	213,247,973.16	237,337,350.26
4	ХАЦЭХ-ний тоо хэмжээний өсөлтөөр	105.84%	100.83%	111.84%
5	Дотоод тооцооны үнийн өсөлтөөр	102.88%	114.30%	99.51%

6	ХАЦЭХ-ний тоо хэмжээний өсөлтөөр,мян төгрөг	14,029,579.25	29,274,626.98	24,089,377.10
7	Дотоод тооцооны үнийн өөрчлөлт,мян төгрөг	5,177,379.31	26,675,408.15	-1,164,184.96
	<b>Нийт өөрчлөлтийн дүн</b>	<b>19,206,958.56</b>	<b>55,950,035.13</b>	<b>22,925,192.13</b>

- Худалдан авсан ЦЭХ-ний тоо хэмжээний өсөлтөөр 11.8 хувиар буюу 24,089.3 сая төгрөгөөр буурч,

- Дотоод тооцооны үнийн өсөлтөөр -0.49 хувиар буюу -1,164.1 сая төгрөгөөр өсч, ХАЦЭХ-ийн ба дотоод тооцооны үнийн өсөлтөөр нийтдээ 22,925.1 сая төгрөгөөр ашиг буурахад хүрсэн байна.

**Хүснэгт -21. Борлуулсан ЦЭХ ба дундаж үнийн өөрчлөлтийн нөлөөллийн шинжилгээ**

	Үзүүлэлт	2019-II	2020-II	2021-II
1	Борлуулсан ЦЭХ, мян.,кВтц	1,361,502.8	1,387,573.5	1,552,445.6
2	Дундаж үнэ, төгрөг	142.6	162.1	159.2
3	ЦЭХ-ийн орлого мян.төг	191,505,100.8	217,552,491.0	245,088,109.0
4	Борлуулсан ЦЭХ-ийн тоо хэмжээний өсөлт	106.7%	101.9%	111.9%
5	Дундаж үнийн өсөлт	101.8%	113.6%	98.2%
6	ЦЭХ-ийн орлогын өсөлт мян.төг	15,626,940.9	26,047,390.2	27,535,618.0
7	Түгээх үйл ажиллагааны өсөлт,мян төг	104,564.5	3,751,873.7	(2,743,074.6)
8	Үндсэн бус үйл ажиллагааны орлогын өсөлт	1,114,859.7	95,483.6	(1,961,109.6)
	<b>Нийт өөрчлөлтийн дүн</b>	<b>16,846,365.1</b>	<b>29,894,747.6</b>	<b>22,831,433.8</b>

- Борлуулсан ЦЭХ-ний өсөлт 11.9 хувиар буюу 27,535.6 сая төгрөгөөр ашиг өсч,
- Түгээх үйл ажиллагааны орлогын бууралтаар -2,743.0 сая төгрөгөөр ашиг буурч,
- Үндсэн бус үйл ажиллагааны орлогын өсөлтөөр -1,961.1 сая төгрөгөөр ашиг буурч нийт дүнгээрээ 22,831.4 сая төгрөгөөр орлого өссөн байна.

**Хүснэгт -22. ЦЭХ алдагдлын өсөлтийн нөлөөллийн шинжилгээ**

	Үзүүлэлт	2019-II	2020-II	2021-II	
1	ХАЦЭХ, мян.кВтц	1,540,886.7	1,553,605.6	1,737,589.5	
2	Бор ЦЭХ, мян.кВтц	1,361,502.8	1,387,573.5	1,552,445.6	
3	Алдагдал хувь	төлөвлөгөө	13.04	12.23	11.78
4		хувь	11.64	10.69	10.66
5	Алдагдал, мян.кВтц	төлөвлөгөө	200,960.81	189,963.26	195,217.00
6		хувь	179,383.91	166,032.13	185,143.89
7	Алдагдлын бууралтын зөрүү	мян.кВтц	21,576.90	23,931.13	10,073.11
8	ЦЭХ-ийн өртөг	мян.төгрөг	2,591,169.92	3,284,786.90	1,375,886.09
9	ЦЭХ-ийн орлого	мян.төгрөг	3,076,865.94	3,878,039.62	1,603,639.11
	<b>Алдагдлын бууралтаар бий болсон ашиг</b>	<b>485,696.02</b>	<b>593,252.71</b>	<b>227,753.02</b>	

-ЦЭХ-ийн алдагдлын бууралтаар төлөвлөгөөнөөс 227.7 сая төгрөгийн ашиг өссөн нь өмнөх жилийн мөн үеийн үзүүлэлтээс 38 хувиар бага байна.

#### Хүснэгт -23. Үйл ажиллагааны зардлын нөлөөллийн шинжилгээ

ҮА-ны чиглэл	2018-II	2019-II	2020-II	2021-II	зардалд эзлэх хувь	2021/ 2020	2021/ 2019	2021/ 2018
Түгээх	15,985.6	17,326.4	19,418.7	19,925.4	54%	103%	115%	125%
Хангах	11,634.5	11,525.0	12,583.2	12,003.5	33%	95%	104%	103%
Нийтлэг	3,898.3	3,937.9	5,798.1	4,632.8	13%	80%	118%	119%
<b>Үндсэн ү/а-ны зардал</b>	<b>31,518.4</b>	<b>32,789.3</b>	<b>37,800.1</b>	<b>36,561.6</b>	<b>100%</b>	<b>97%</b>	<b>112%</b>	<b>116%</b>
Үндсэн бус ү/а-ны зардал	2,440.5	3,192.9	3,201.4	2,297.0	7%	72%	72%	94%
<b>Нийт зардал</b>	<b>29,077.9</b>	<b>29,596.3</b>	<b>34,598.7</b>	<b>34,264.6</b>				

Үйл ажиллагааны зардал нийт дүнгээр өмнөх оны мөн үеэс 3 хувиар буюу 1,238.5 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Нийт зардлын өөрчлөлтийг үйл ажиллагааны чиглэлээр авч үзвэл Түгээх үйл ажиллагааны зардал өмнөх үеэс 3 хувийн өсөлттэй, Хангах үйл ажиллагааны зардал 5 хувийн бууралттай, Нийтлэг үйл ажиллагааны зардал 20 хувийн бууралттай, мөн бусад зардал нь 28 хувийн бууралттай байна.

## ТАВ. АВЛАГА, ӨР ТӨЛБӨРИЙН ҮЗҮҮЛЭЛТ

### Авлагын шинжилгээ

Нийт авлага 62,564.0 сая төгрөг байгаагийн 48.3 хувийг цахилгаан эрчим хүчний авлага, Засгийн газрын 199 дүгээр тогтоолын хүрээнд гэр хорооллын айл өрхөд үзүүлэх тарифийн хөнгөлөлтийн авлага 22.8 хувь, Засгийн газрын 211 дүгээр тогтоолын хүрээнд Цахилгаан эрчим хүчний хөнгөлөлтийн авлага 22.2 хувийг эзлэж байна. Хэрэглэгчдээс цуглуулах цахилгаан эрчим хүчний авлага өнгөрсөн оны мөн үеэс 1,922.5 сая төгрөгөөр, харин оны эхнээс 7,726.2 сая төгрөгөөр буурсан байна.

#### Хүснэгт 24. Авлагын бүтэц

Авлагын төрөл	2019-II	2020-II	2021-II	2020-IV	Өөрчлөлт			
					өмнөх үеэс		өмнөх оноос	
<b>Нийт авлагын дүн</b>	<b>36,972.6</b>	<b>42,531.1</b>	<b>62,564.0</b>	<b>59,190.2</b>	<b>20,032.9</b>	<b>147%</b>	<b>3,373.8</b>	<b>95%</b>
ЦЭХ-ийн авлага	23,489.2	28,277.5	30,200.0	37,926.1	1,922.5	107%	-7,726.2	126%
Бусад авлага	13,483.5	14,212.1	32,364.1	21,264.0	18,152.0	228%	11,100.0	66%
Үүнээс : ЗГ-н хөнгөлөлтийн авлага	11,485.6	11,642.7	28,131.9	20,099.0	16,489.2	328%	8,032.9	71%
Бэлтгэн нийлүүлэгчийн авлага	1,997.8	2,569.4	4,232.1	1,165.0	1,662.7	428%	3,067.1	28%
Татварын авлага		41.5			-41.5			

Борлуулалтын бодлогын хэлтсээс авлагын насжилтийн судалгааг гаргаж насжилт өндөртэй авлагын шалтгааныг тодорхойлох, шинээр авлага үүсгэхгүй байх, авлагын дэг жаягийг мөрдөж ажиллах зэрэгт анхаарч байна.

## Богино хугацаат өр төлбөрийн шинжилгээ

ДҮТ ТӨХХК-д 2021 оны эхний хагас жилийн байдлаар тухайн оны төвлөрүүлэх орлогоо 95.3 хувиар биелүүлэн ажилласан боловч оны эхний өр төлбөр 44,163.8 сая төгрөгийн үлдэгдлийн хамт 54,679.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй болсон байна. Төвлөрүүлэлтийн өглөгийн өсөлтөнд засгийн газрын хөнгөлөлтүүдтэй холбоотой 28,131.9 сая төгрөгийн авлага, буцах санхүүжилтийн илүү төвлөрүүлэлт нөлөөлсөн байна.

### Хүснэгт 25. Төвлөрүүлэлтийн үлдэгдэл

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2019-II	2020-II	2021-II	Өсөлт, бууралт		
					2019-II	2020-II	2021-II
ХАЦ	сая.кВтц	1,540.89	1,553.61	1,737.59	105.8%	100.8%	111.8%
Дотоод тооцооны үнэ	төг/кВтц	120.09833	137.26	136.59	102.9%	114.3%	99.5%
Төвлөрүүлбэл зохих орлого	сая төг	169,013.45	201,988.42	226,604.18	110.0%	119.5%	112.2%
ТҮОНДансанд	сая төг	167,998.74	196,186.51	216,088.21	108.6%	116.8%	110.1%
Төвлөрүүлэлтийн дутуу		-1,014.71	-5,801.91	-10,515.97			
эхний үлдэгдэл		-16,374.08	-20,148.69	-44,163.81			
Төвлөрүүлэлтийн үлдэгдэл		(17,388.79)	(25,950.60)	(54,679.78)			

**Энэ хэсэгт байсныг бүхэлд нь хассан**

### Хүснэгт 26. Богино хугацаат өр төлбөрийн бүтэц, сая.төг

	БХӨТ-ийн төрөл	2019-II	2020-II	2021-II	2020-IV	Өөрчлөлт /өмнөх үеэс/		оны эхнээс
	<b>Нийт БХӨТ-ийн дүн</b>	<b>45,131.7</b>	<b>39,290.0</b>	<b>64,895.9</b>	<b>57,319.8</b>	<b>25,605.94</b>	165%	7,576.1
1	Дансны өглөг	17,388.8	25,950.6	54,679.8	44,163.8	28,729.19	211%	10,516.0
2	Цалингийн өглөг				2,700.1			-2,700.1
3	Татварын өглөг	2,032.1	310.5	930.9	930.9	620.4	300%	0.0
4	НДШ-ийн шимтгэлийн өглөг	19.3	-	7.9	7.9	7.9		0.0
5	Богино хугацаат банкны зээл	6,251.0	-	-				
6	Бусад өглөг	18,182.9	11,853.2	7,081.7	5,241.8	-4,771.49	60%	1,839.9
7	Урьдчилж орсон орлого	1,257.7	1,175.6	2,195.6	4,275.2	1,019.94	187%	-2,079.6

Өмнөх оны мөн үеэс богино хугацаат өглөг 25.605.9 сая төгрөгөөр өссөн, харин оны эхнээс 7,576.1 сая төгрөгөөр өсөлттэй байгаа нь Засгийн газрын 211 тогтоолын хүрээнд эрчим хүчний төлбөрийг хөнгөлсөнтэй холбоотойгоор төвлөрүүлэлтийн өглөгийн үлдэгдэл нөлөөлжээ. Энэ нь авлага өглөгийн өсөлт нь хоорондоо нягт хамааралтайг харуулж байна.

## Урт хугацаат өр төлбөр

Урт хугацаат өр төлбөр 55,338.45 сая төгрөг байгаагаас 29,645.82 сая төгрөг нь Дэлхийн банкны урт хугацаат зээл, 50.7 сая төгрөг нь Азийн хөгжлийн банкнаас дамжуулан зээлсэн зээл байна.

Хүснэгт 27. Урт хугацаат өр төлбөрийн бүтэц, мянган төгрөгөөр

Энэ хүснэгт өөрчлөгдсөн

	УХӨТ-ийн төрөл	2019-II	2020-II	2020-IV	2021-II	Өөрчлөлт /өмнөх үеэс/	
						өмнөх үеэс	оны эхнээс
	<b>Нийт УХӨТ-ийн дүн</b>	<b>54,625.07</b>	<b>52,488.47</b>	<b>60,289.49</b>	<b>55,338.45</b>	2,849.98	(4,951.0)
1	АХБ-ны зээл	57.62	53.02	50.724	50.72	-2.30	(0.0)
2	Дэлхийн банкны зээл	34,345.36	32,050.92	30,820.69	29,645.82	-2,405.10	(1,174.9)
3	Бусад урт хугацаат зээл	20,222.09	20,384.53	29,418.08	25,641.91	5,257.38	(3,776.2)

Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлсэн эрчим хүчний алдагдал бууруулах MOG-3503, MOG-4673 төслийн дамжуулан зээлдүүлсэн гэрээний зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу 1,174.9 сая төгрөгийг төлсөн. Бусад урт хугацаат өглөгийн хувьд хувь хүн хуулийн этгээдээс үнэ төлбөргүй хүлээлгэн өгсөн хөрөнгийг бүртгэдэг бөгөөд хагас жилийн байдлаар 564.3 сая төгрөгийн хойшлогдсон орлогыг хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

## ЗУРГАА. ХӨРӨНГИЙН БҮТЦИЙН ШИНЖИЛГЭЭ

### Эргэлтийн хөрөнгийн шинжилгээ

Эргэлтийн хөрөнгийн гол бүрэлдэхүүн болох мөнгөн хөрөнгө, авлагын асуудал нь эрчим хүчний хангах түгээх үйлчилгээ эрхэлдэг компанид онцлогтой учир шинжилгээний өмнөх хэсэгт авч үзсэн.

Хүснэгт -28. Эргэлтийн хөрөнгийн бүтэц

Энэ хүснэгтийн 1 тоо өөрчлөгдсөн

ХӨРӨНГӨ	2019-II		2020-II		2020-IV		2021-II	
	Мөнгө	Бүтэц	Мөнгө	Бүтэц	Мөнгө	Бүтэц	Мөнгө	Бүтэц
<b>Мөнгө</b>	<b>3,113.7</b>	<b>6%</b>	<b>4,456.1</b>	<b>8%</b>	<b>787.0</b>	<b>1%</b>	<b>13,246.7</b>	<b>16%</b>
Бэлэн мөнгө	21.9		41.1		24.9		26.2	
Харилцах	3,091.8		4,415.0		762.1		13,220.5	
<b>Авлага</b>	<b>36,972.6</b>	<b>71%</b>	<b>42,531.1</b>	<b>73%</b>	<b>65,328.2</b>	<b>87%</b>	<b>62,564.0</b>	<b>73%</b>
Дансны авлага	26,138.0		30,872.6		40,995.2		33,269.0	
Бусад авлага	13,483.5		14,253.6		21,264.0		32,364.0	
Найдваргүй авлагын нөөц	(2,648.8)		(2,595.1)		3,069.0		(3,069.0)	

<b>Бараа материал</b>	<b>11,625.1</b>	<b>22%</b>	<b>11,473.4</b>	<b>20%</b>	<b>8,726.7</b>	<b>12%</b>	<b>9,382.0</b>	<b>11%</b>
Бараа материал	13,762.0		13,774.3		11,588.1		12,243.3	
Бараа материалын хасагдуулга	(2,136.9)		(2,300.9)		(2,861.4)		(2,861.4)	
<b>Урьдчилж төлсөн төлбөр</b>	<b>172.8</b>	<b>0%</b>	<b>128.7</b>	<b>0%</b>	<b>111.1</b>	<b>0%</b>	<b>162.9</b>	<b>0%</b>
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</b>	<b>51,884.2</b>	<b>100%</b>	<b>58,589.2</b>	<b>100%</b>	<b>74,953.0</b>	<b>100%</b>	<b>85,355.6</b>	<b>100%</b>

Зураг 2. Эргэлтийн хөрөнгийн бүтэц



Эргэлтийн хөрөнгийн онцлох хэсэг авлага байсаар ирсэн. Ялангуяа 2020, 2021 онуудад засгийн газрын хөнгөлөлттэй холбоотойгоор бусад авлага огцом өссөн байна.

Хүснэгт 29. Бараа материалын үлдэгдлийн бүтэц сая.төг

Д/д	Төрөл	Хөрөнгийн дүн				Хөрөнгийн бүтэц	
		2019-II	2020-II	2020-IV	2021-II	2020-IV	2021-II
1	Үндсэн сэлбэг хэрэгсэл	11,324.39	10,533.95	8,430.84	9,048.64	97%	96%
2	Багаж хэрэгсэл	152.24	251.37	261.20	253.84	3%	3%
3	Хангамжийн материал	56.82	38.10	65.61	38.09	1%	0%
4	Шатахуун ба шингэн түлш	102.22	71.37	61.49	83.16	1%	1%
5	Тосолгооны материал	66.49	131.75	76.84	110.02	1%	1%
6	Тээврийн хэрэгслийн сэлбэг	1,380.18	1,811.93	2,007.73	1,895.81	23%	20%
7	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа	435.75	533.42	406.68	493.03	5%	5%
8	Аваарын нөөц	243.89	402.40	277.67	320.77	3%	3%

9	Бараа материалын хасагдуулга	-2,136.94	-2,300.88	-2,861.37	-2,861.37	-33%	-30%
	<b>НИЙТ</b>	<b>11,625.05</b>	<b>11,473.40</b>	<b>8,726.70</b>	<b>9,381.97</b>		

Энэ хэсэгт бараа материалын удирдлагад хийсэн шинжилгээг тусгалаа.

Компанийн бараа материалыг дараах хүснэгтэд тусгагдсан ангиллаар ангилж нягтлан бодох бүртгэлд тусгадаг.

Бараа материалын агуулахын үлдэгдлийг зохистой түвшинд барих, насжилтыг бууруулахад байнга анхаарч байна. Бараа материалын худалдан авалтыг зохион байгуулахдаа агуулахын үлдэгдэл, тухайн жилийн хэрэгцээ, өвлийн их ачааллын үед заавал байлгах нөөцийн хэмжээ зэргийг тооцоолон үндэслэлтэйгээр төлөвлөж байна. Гэсэн хэдий ч өдөр бүр өсөн нэмэгдэж буй хэрэгцээ шаардлага, үнийн өсөлтөөс нэгж бүтээгдэхүүний үнэд нөлөөлснөөр тоон үзүүлэлтээр буурах боломжгүй байна.

Хангамжийн үйл ажиллагааг төвлөрсөн байдлаар зохион байгуулж төлөвлөлт, хангамж болон үндсэн үйл ажиллагааны нэгжүүдийн ажлын уялдааг сайжруулснаар салбаруудад байх бараа материалын үлдэгдэл буурч байгаа хэдий ч насжилт өндөртэй 800.0 сая орчим төгрөгийн бараа материал агуулахад хадгалагдаж байна. Дэлхийн банкны төслийн санхүүжилтээр нийлүүлэгдсэн энэ бараа материалыг цаашид худалдан борлуулах, ашиглалтаас хасах замаар эргэлтийг сайжруулахад анхаарах шаардлагатай. Учир нь жил бүрийн аудитын дүгнэлтээр бараа материалын насжилт өндөртэй үлдэгдлийг бууруулахыг удаа дараа анхааруулж аудитын зөрчилтэй үйл ажиллагаанд оруулж ирсэн.

### Эргэлтийн бус хөрөнгийн бүтцийн шинжилгээ

Үндсэн хөрөнгө цэвэр дүнгээрээ урд оноос 47,990.4 сая төгрөг буюу 21 хувиар өссөн нь өмнөх онтой харьцуулбал, 18 пунктээр өндөр өсөлт болно. 2018 оноос хойш балансын үзүүлэлтээр үндсэн хөрөнгө нь 10.3-20.5 хувиар өсч байсан байна. Уг хөрөнгийн өсөлтийг задалж үзвэл,

- Улсын, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй “Гэр хорооллын хүчдэлийн унаттай болон шинэ суурьшлийн бүсийн гэр хорооллын айл өрхийг цахилгаан хангамжаар хангах” багц ажлуудын 35/10 кВа дэд станц, ЦДАШ 35/10кВ, ЦДКШ 35/10кВ, 10кВ-ийн шугамууд, хувиарлах дэд станц, ХТП, АТП, айл өрхийн тоолуур, щит
- Иргэн, аж ахуйн нэгжийн өөрийн хөрөнгөөр барьж байгуулсан гадна цахилгаан хамгамжийн ХТП, АТП, ЦДКШ, ЦДАШ, хэрэглэгчийн тоолуур хэмжих хэрэгсэл
- 2020 оны эцсийн байдлаар байсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 31,717.0 сая төгрөгийн цаашид ашиглах боломжтой үндсэн хөрөнгийг дахин үнэлэх ажил зохион байгуулахаар 2021 оны ажлын төлөвлөгөөнд тусгаад байна.

### Хүснэгт 30. Эргэлтийн бус хөрөнгийн бүтэц ба хуучралт, элэгдэл

Үндсэн хөрөнгө	2020-II			2020-IV			2021-II		
	Дансны өртөг	Хуримтлагдсан элэгдэл	хөрөнгийн хуучралт	Дансны өртөг	Хуримтлагдсан элэгдэл	хөрөнгийн хуучралт	Дансны өртөг	Хуримтлагдсан элэгдэл	хөрөнгийн хуучралт

				элэгд эл			элэгд эл			элэгд эл
1	Газрын сайжруулалт	2,119			2,119			2,119		
2	Барилга байгууламж	35,612	2,645	7%	41,653	3,187	8%	41,788	3,747	9%
3	Машин, тоног	279,132	105,370	38%	333,147	111,361	33%	337,858	118,230	35%
4	Тээврийн хэрэгсэл	9,479	5,432	57%	9,618	5,847	61%	9,629	6,206	64%
5	Тавилга эд хогшил	2,235	1,305	58%	2,319	1,364	59%	2,342	1,446	62%
6	Компьютер, бусад хэрэгсэл	10,833	5,273	49%	11,051	5,715	52%	11,678	6,745	58%
7	Бусад үндсэн хөрөнгө	408	400	98%	289	285	99%	289	286	99%
8	Биет бус хөрөнгө	3,082	2,464	80%	3,177	2,628	83%	3,186	2,755	86%
		<b>342,901</b>	<b>122,889</b>		<b>403,372</b>	<b>130,387</b>		<b>408,889</b>	<b>139,415</b>	

Хөрөнгөд эзлэх хуримтлагдсан элэгдлийн хэмжээнээс харахад 1.4 пунтээр буурсан мэт харагдаж байгаа боловч үр дүн хөрөнгийн хуучралт 30 хувиас буурахгүй байгаа нь цахилгаан эрчим хүчний найдвартай ажиллагааг хангах нийгмийн өмнө өндөр хариуцлага хүлээсэн манай компанийн хувьд эрсдэл өндөртэй гэж харж байна.

2021 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангаар 33,200.0 сая төгрөгийн анхны өртгөө элэгдлээрээ нөхсөн хөрөнгө байгаа бөгөөд нийт үндсэн хөрөнгөний 8.1 хувийг эзэлж байна. Дээрх үлдэх өртөггүй үндсэн хөрөнгийн 85.0 хувийг дэд станцын тоноглол, цахилгаан дамжуулах агаарын шугам, тоолуур хэмжих хэрэгсэл, щит, лабораторийн тоног төхөөрөмж, хүчний трансформатор зэрэг хөрөнгө эзэлж байна. Компани нь жилдээ дунджаар нийт хөрөнгийн 5-6 хувьд нь их засвар, ТЗБАХ хийдэг гэвэл 202 оны эхний жилийн байдлаар 13,918.4 сая төгрөгийн Хөрөнгө оруулалт, их засварын ажлын санхүүжилт батлагдсан бөгөөд гүйцэтгэлээр 2341.5 сая төгрөгийн ажил хийгдээд байна.

## ДОЛОО. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ШИНЖИЛГЭЭ

### Ашгийн үзүүлэлт

Компанийн 2021 оны санхүү байдлын тайланг сүүлийн 3 жилийн байдлаар, оны эхний үлдэгдэлтэй зэрэгцүүлж өсөлт бууралтыг харуулбал:

Хүснэгт -28. 2019-2021 онуудын хагас жилийн санхүүгийн үзүүлэлт сая.төг

Балансын зүйл	2019.06.30	2020.06.30	2020.12/31	2021.06.30	2021- II	2020- II
<b>ХӨРӨНГӨ</b>						
<b>Эргэлтийн хөрөнгө</b>						
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	3,113.8	4,456.1	787.0	13,246.7	0.16	0.01
Дансны авлага	36,972.6	42,531.1	59,190.2	62,564.0	0.73	0.86
Бараа материал	11,625.0	11,473.4	8,726.7	9,382.0	0.11	0.13



Урьдчилж төлсөн зардал тооцоо	172.8	128.7	111.1	162.9	0.00	0.00
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>51,884.3</b>	<b>58,589.3</b>	<b>68,815.0</b>	<b>85,355.6</b>	<b>0.24</b>	<b>0.20</b>
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>						
Үндсэн хөрөнгө	220,662.1	219,394.0	270,316.9	266,923.5	0.99	0.99
Биет бус хөрөнгө	667.3	617.6	2,668.5	2,550.2	0.01	0.01
Бусад хөрөнгө	24,494.2	8,054.4	565.9	695.7	0.00	0.00
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>245,823.6</b>	<b>228,065.9</b>	<b>273,551.3</b>	<b>270,169.4</b>	<b>0.76</b>	<b>0.80</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>297,707.9</b>	<b>286,655.2</b>	<b>342,366.2</b>	<b>355,524.9</b>		
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>						
Богино хугацаат өр төлбөр	45,131.7	39,289.9	57,855.3	64,895.9	0.54	0.49
Урт хугацаат өр төлбөр	54,625.1	52,433.2	60,289.5	55,338.5	0.46	0.51
<b>Нийт өр төлбөрийн дүн</b>	<b>99,756.8</b>	<b>91,723.1</b>	<b>118,144.8</b>	<b>120,234.3</b>	<b>0.34</b>	<b>0.35</b>
<b>Эздийн өмч</b>						
Төрийн өмч	80,626.9	118,530.9	118,530.9	118,530.9	0.50	0.53
Эздийн өмчийн бусад хэсэг	105,373.8	67,613.3	109,325.8	114,541.2	0.49	0.49
Хуримтлагдсан ашиг	11,950.4	8,787.8	(3,635.2)	2,218.5	0.01	(0.02)
<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>197,951.1</b>	<b>194,932.0</b>	<b>224,221.4</b>	<b>235,290.6</b>	<b>0.66</b>	<b>0.65</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>297,707.9</b>	<b>286,655.2</b>	<b>342,366.2</b>	<b>355,524.9</b>		

Санхүүгийн тайлангийн үзүүлэлтээс харахад эргэлтийн хөрөнгийн 73-86 хувийг дансны авлага, эргэлтийн бус хөрөнгө нь нийт хөрөнгийн 76-80 эзлэж байгааг харж болно.

Харин сүүлийн жилүүдэд дансны өглөгө өссөнөөр богино хугацаат өглөгийн дүн урт хугацаат өглөгтэй зэрэгцэж очсон байна.

2019-2020 онуудад эхний хагасж жилийн байдлаар татвар төлөхийн өмнөх ашиг тогтмол эерэг гарч байсан бөгөөд 2021 оны тайлант хугацаанд 2,831.3 сая төгрөгийн ашигтай ажилласан. Энэхүү ашиг алдагдалд нөлөөллийг ашгийн үзүүлэлт хэсэгт тайлбарласан.

## Харьцааны шинжилгээ, дүгнэлт

Шинжилгээнд ашиглагдах олон харьцаанаас компанийн үйл ажиллагаанд чухал хамааралтай гол харьцааг авч дүн шинжилгээ хийж үздэг. Үүнд:

- Төлбөрийн чадварын харьцаа
- Өр төлбөрийн удирдлагын харьцаа
- Ашигт ажиллагааны харьцаа

### Хүснэгт -29. Төлбөрийн чадварын харьцаа

Харьцаа	2018-II	2019-II	2020-II	2021-II	2020-IV
Нийт эргэлтийн хөрөнгө	41,754.95	51,884.33	58,589.27	85,355.57	68,814.96
Богино хугацаат өглөг	17,532.70	45,131.74	39,289.95	64,895.89	57,855.31
Ажлын капитал	24,222.24	6,752.58	19,299.32	20,459.68	10,959.65
Эргэлтийн харьцаа	2.38	1.15	1.49	1.32	1.19

Түргэн хөрвөх чадварын харьцаа	1.79	1.29	1.24	1.12	1.15
--------------------------------	------	------	------	------	------

Эргэлтийн харьцаа 2018 оны эхний хагаст зохист хэмээнд байсан боловч 2019 оноос эхлэн буурч ирсэн байна. Гэсэн авлага өглөгийн өсөлт нь дансны авлага, дансны өглөгөөр өссөн тул харьцаанд том өөрчлөлт гараагүй байна. Харин Түргэн хөрвөх чадвар зохистой харьцаа 2019 оноос буурч эхэлсэн байна. Сүүлийн жилүүдэд нийт эргэлтийн хөрөнгийн дүнд эзлэх авлагын үлдэгдэл байнга өсч ирсэн.

### Хүснэгт 30. Хөрөнгийн эргэцийн шинжилгээ

Харьцааны нэр	2019-II	2020-II	2021-II
Авлага цуглуулах дундаж хугацаа	54.52	56.11	79.28
Үндсэн хөрөнгийн эргэц	1.01	1.13	1.13
Нийт хөрөнгийн эргэц	0.77	0.89	0.79

Авлага цуглуулах дундаж хугацааг 2020 оны мөн үеэс 23.17 хоногоор нэмэгджээ. Авлагын өсөлт нь ААН-ийн хэрэглэгчдэд илүү байгаа болно. Зураг 2-оос харна уу.

Үндсэн хөрөнгийн эргэц нь эздийн өмчийн 75 орчим хувийг эзлэх нь зохистой гэж үздэг ч манай компанийн нийт хөрөнгийн 80 орчим хувь нь үндсэн хөрөнгө тул энэ харьцааг барих боломжгүй байдаг. Энэ утгаараа эргэцэд байгаа 1 төгрөгийн үндсэн хөрөнгөө ашиглаж 1.13 төгрөг олж байна.

Компанийн хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хангах, түгээх шугам, тоноглолын өсөлт дараах эх үүсвэрээс бий болж байна.

1. Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар айл өрхийн цахилгаан хангамжийг сайжруулах ажлаар бий болсон шугам тоноглолын нэмэлт бүртгэл,
2. Хувийн хэвшлийн болон ард иргэдийн хувийн хөрөнгө оруулалтаар хийгдэж, ашиглалтыг УБЦТС ТӨХК-д хариуцуулахаар үнэ төлбөргүй шилжүүлж байгаа хөрөнгийн бүртгэл, энэ тохиолдолд компанийн өөрийн эзэмшилд үнэ төлбөргүй шилжүүлэн авч, түүний ашиглалтын хэвийн, найдвартай, аваар осолгүй ажиллуулах үүрэг хариуцлагыг хүлээдэг.
3. Өөрийн эх үүсвэрээр буюу тухайн тайлангийн жилд байгуулсан элэгдлийн зардлаар шугам тоноглолын засвар шинэчлэлт, ТЗБАХ-ын арга хэмжээнүүдийг хэрэгжүүлснээр тэдгээрт гарсан зардлын капиталжуулах зэрэг болно.

### Хүснэгт -31. Тогтвортой байдлын үнэлгээ

№	Үзүүлэлт	Шалгуур	2019-II	2020-II	2021-II
1	Бие даах чадварын коэффициент	0.6<0.8	0.66	0.68	0.66
2	Зохицуулалтын коэффициент	Эерэг болон өссөн байх	0.16	0.14	0.09
3	Өөрийн ба гадаад капиталын харьцаа	Эерэг болон буурсан байх	0.50	0.47	0.51

4	Гадны капиталын хувийн жин	Буурсан байх	0.34	0.32	0.34
5	Байнгын капиталын бүтэц	Эерэг болон буурсан байх	0.25	0.24	0.21
<b>6</b>	<b>Альтманы индекс</b>	<b>&gt;2.67</b>	<b>2.84</b>	<b>3.10</b>	<b>2.99</b>
7	K1		0.02	0.01	0.01
8	K2		0.64	0.76	0.78
9	K3		1.98	2.13	1.96
10	K4		0.02	0.01	0.01
11	K5		0.17	0.20	0.24

Дээрх шинжилгээ нь Сангийн сайдын баталсан жишиг шинжилгээний загвар тул энэ хэсэгт оруулж ирсэн байна.

Гадны капиталын хувийн жин өссөн шалтгаан нь урт хугацаат өглөгөөр хойшлогдсон орлогыг бүртгэсэнтэй холбоотой гэж харж байна.

Санхүүгийн эрүүл байдлын индекс болох Альтманы индекс 2.99 байгаа нь зохих түвшинд байна.

ХЯНАСАН: НИЙТЛЭГ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛСЭН  
ДЭД ЗАХИРАЛ

О.ОТГОНБАЯР

БОЛОВСРУУЛСАН:

Д.ТӨГСЖАРГАЛАН

